



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/02

Мандалговь

2019 оны Цэргийн бүртгэл  
явуулах тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 4.4 дүгээр зүйл, 9 дүгээр бүлэг, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019 оны Цэргийн бүртгэл явуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Ц.Эрдэнэсүрэн(Аймгийн Засаг даргын Тамгын дарга)
Орлогч дарга:	Ш.Гансүх(Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
Нарийн бичгийн дарга:	Г.Цэрэндолгор(Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, хошууч)
Гишүүд:	Ц.Баттулга(Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч) Сумдын Засаг дарга нар

Хоёр. Аймгийн цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл алба хаах насны иргэдийн цэргийн бүртгэлийг 2019 оны 1 дүгээр сарын 3-наас 1 дүгээр сарын 20-ны дотор зохион байгуулж явуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, (Ц.Эрдэнэсүрэн) сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Сум, багуудад цэргийн бүртгэлийн ажлыг хүн ам тоо бүртгэлтэй нягт уяалдуулан зохион байгуулж гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гарган ажилуулсугай.

Дөрөв. Сумдад цэргийн бүртгэл хэрхэн явагдаж байгаад хяналт, үнэлгээ, шинжилгээ хийхэд зориулж цэргийн тоо бүртгэлийн комисст суудлын автомашинаар үйлчилэхийг ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д зөвшөөрсүгэй.

Тав. Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдад цэргийн цахим тоо бүртгэлийн программ бүхий компьютерийг ашиглан тоо бүртгэл явуулахыг Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер хошууч Г.Цэрэндолгорт даалгасугай.

Зургаа. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

А. Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудын дагуу "Улсын дайчилгааны төлөвлөгөө" болон "Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч техникээр хангах төлөвлөгөө"-ний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар болох хүнс болон эд хэрэгслийн тооцоо, цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг бүртгэн тоолж Цэргийн штабтай тодотгол хийхэд бэлтгэн ирүүлэх.

488010004

Б. Цэргийн тоо бүртгэлийг бие даан явуулж тоо бүртгэлийн мэдээ, тайлангуудыг 2019 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр хэвлэн Монгол Улсын "Төрийн болон албаны нууцын тухай хууль" Засгийн газрын 2017 оны 246 дугаар журмын дагуу нууцлан дэвтэрлэн авчирах (эхийг файлаар авчирах)

В. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан "Батлан хамгаалах"-ын багц хууль, 2018 онд батлагдсан "Орон нутгийн хамгаалалтын тухай хууль" Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр хаах журам" мөн тус оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн гэрээт алба хаах журам" зэрэг бусад холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдийн тухай, цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулан тайланг Цэргийн штабт ирүүлэх.

Г. Цэргийн бүртгэлийн зөрчилтэй болон зайлсхийгчид, завсардагчид, урд онуудын I, II ээлжийн цэрэг татлагад хамрагдаагүй цэргийн үүрэгтнүүдийг эрэн сурвалжлах, бүртгэлд хамруулах ажилд Цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл мэдээлэлийн ажилтанууд болон холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах, тоо бүртгэлийн журам зөрчигчдөд "Цэргийн албаны тухай" хуулийн 11 дүгээр бүлгийн 36 дахь заалтын дагуу хариуцлага хүлээлгэж хэнд, ямар арга хэмжээ авсан тухай мэдээг Цэргийн штабт ирүүлэх.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ